

## ТАЛАРХАЛ

“Өмнөговь аймгийн нийгэм-эдийн засаг, байгаль орчны суурь судалгаа”-ны ажлыг Бодлого Судлалын Төвөөс 2008 оны 5-11 дүгээр сард гүйцэтгэлээ. Энэ ажлыг гүйцэтгэхэд МУИС-ийн Хүн Амын Сургалт, Судалгааны Төв, Геологийн Төв Лаборатори, Үндэсний Статистикийн Хороо зэрэг бусад байгууллагын эрдэмтэд судлаачдыг багтаасан мэргэжлийн баг бүрдүүлж ажиллав. Судалгааны ажилд нийгэм-эдийн засаг, байгаль орчин, институцийн асуудлыг үндэсний, аймгийн ба сумын түвшинд авч үзсэн болно.

Тус аймгийн бүх 15 сумыг хамруулан тэдний оролцоотойгоор энэхүү судалгааг бүрэн явуулахад бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлсэн сумын төр захиргаа, байгууллага, аж ахуйн нэгж, малчид, иргэдэд талархлаа илэрхийлж байна.

Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Засаг Даргын Тамгын Газар, Статистикийн Хэлтэс болон аймгийн мэргэжлийн албадаас удирдлага, зохион байгуулалтын ба мэргэжлийн үнэтэй дэмжлэг, туслалцаа үзүүлсэн явдалд талархаж байна.

Айвенхоу Майнз Монголиа ХХК-ийн багийн гишүүд ноён К.Лэйтон, ноён Ибо Блазицевич, хатагтай Г.Сугар, хатагтай Д.Олжмэдэх нараас үзүүлсэн ажлын удирдамж чиглэл судалгааны ажлыг амжилттай хэрэгжүүлэхэд чухал боломж бүрдүүлж өгснийг талархалтайгаар тэмдэглэж байна.

Энд нэр цохож дурьдаагүй боловч манай ажилд өөрсдийн зүгээс шаардлагатай дэмжлэг үзүүлж байсан бусад байгууллага, хувь хүмүүст талархсанаа илэрхийлье.

## **ТӨСЛИЙН СУДАЛГААНЫ БАГ:**

### **Бодлого нудлалын дөв**

- |    |                |   |
|----|----------------|---|
| 1. | А.Энх-Амгалан  | Судалгааны багийн ахлагч, Төвийн Тэргүүн, доктор        |
| 2. | Б.Эрдэнэбаатар | Хөдөөгийн хөгжлийн зөвлөх, ШУ-ны доктор                 |
| 3. | С.Амгаа        | Бизнес хөгжлийн зөвлөх, Доктор                          |
| 4. | Ц.Володя       | Малчдын бүлгийн зөвлөх, ШУ-ны доктор                    |
| 5. | О.Төмөрцож     | Малчдын бүлгийн зөвлөх                                  |
| 6. | Д.Батбаяр      | Газрын менежмент, газар зүйн мэдээллийн зөвлөх, магистр |
| 7. | Ө.Наран-Очир   | Газрын менежмент, газар зүйн мэдээллийн зөвлөх, магистр |
| 8. | А.Болдсүх      | Бизнес хөгжлийн зөвлөх, магистр                         |
| 9. | Б.Ганбаяр      | Эдийн засагч, мэдээлийн технологич                      |

### **Бодлого судлалын төвийн зөвлөхүүд**

- |     |                |   |
|-----|----------------|---|
| 1.  | Э.Төмөрбаатар  | Байгаль орчны мэргэжилтэн, магистр  |
| 2.  | Э.Гэрэлт-Од    | Улс төр судлаач, УБИС-ийн багш  |
| 3.  | П.Лхам         | Түүхч, магистр, Японы Осакагийн Гүнзгийрүүлсэн судалгааны их сургуулийн докторант |
| 4.  | А.Алтанзул     | Хуульч, Удирдлагын академийн ахлах багш, доктор                                   |
| 5.  | С.Туул         | Лабораторийн шинжээч, Геологийн төв лаборатори, доктор                            |
| 6.  | Ч.Пүрэвсүрэн   | Гидрогеологич инженер, магистр  |
| 7.  | С.Хандсүрэн    | ХААИС-ийн Эдийн засаг, бизнесийн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор |
| 8.  | Ш.Дэнсмаа      | ХААИС-ийн Эдийн засаг, бизнесийн сургуулийн багш, докторант                       |
| 9.  | С.Шийрэв-Адъяа | Газарзүйч, Газарзүйн хүрээлэн, доктор   |
| 10. | Ч.Баяр         | Газарзүйч, магистр  |
| 11. | З.Нансалмаа    | ҮСХ-ны Мэдээлэл боловсруулалт, технологийн газрын ахлах мэргэжилтэн               |
| 12. | А.Амарбал      | Хүн ам зүйч, доктор   |
| 13. | А.Дэмбэрэл     | Эдийн засагч, МУИС-ийн докторант  |

### **Монгол Улсын их сургуулийн Эдийн засгийн сургуулийн Хүн амын сургалт, судалгааны төв**

- |    |                      |  |
|----|----------------------|--|
| 1. | Б. Энхцэцэг          | Доктор, дэд профессор                                |
| 2. | Ц. Болормаа          | Төвийн Захирал, доктор, дэд профессор                |
| 3. | А. Солонго           | Доктор, ахлах багш/судлаач                           |
| 4. | Т. Навч              | Магистр, ахлах багш/судлаач                          |
| 5. | Б. Наранчимэг        | Магистр, багш/судлаач,                               |
| 6. | Томас<br>Спооренбург | Женевийн их сургуулийн докторант, зочин багш/судлаач |

### **Олон улсын зөвлөх**

- |    |         |   |
|----|---------|---|
| 1. | Катерин | Судалгааны захирал, доктор, Австралийн Нийгмийн |
|----|---------|---|

МкДональд тогвортой үйлчилгээ зөвлөх компани  
**ТӨСЛИЙН ЗӨВЛӨХ ХОРОО:**

**Өмнөговь аймгийн гишүүд**

1. С.Цэрэнбаяр ИТХ-ын дарга, зөвлөлдөх хорооны дарга
2. С.Эрдэнэбат Өмнөговь аймгийн Засаг дарга
3. Х.Байгальмаа Өмнөговь аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга
4. О.Бадарч Өмнөговь аймгийн ЗДТГазрын Үйлдвэрлэл, дэд бүтэц, байгаль орчны бодлого зохицуулалтын хэлтсийн дарга
5. Б.Наранцэцэг Өмнөговь аймгийн ЗДТГазрын Нийгмийн бодлого зохицуулалтын хэлтсийн дарга
6. Э.Оюунмаам Өмнөговь аймгийн Статистикийн хэлтсийн дарга
7. Б.Даваацэрэн Гурвантэс сумын Засаг дарга
8. Т.Буян-Өлзий Ханбогд сумын Засаг даргын орлогч
9. Д.Давааням Өмнөговь аймгийн Байгаль орчны албаны дарга
10. Д. Даргахүү Өмнөговь аймгийн Худалдаа аж үйлдвэрийн танхимын ерөнхийлөгч
11. Л.Өлзийжаргал Болор ус ХХК-ны захирал
12. Б.Эрдэнэ-Очир Ханбогд холбоо ТББ-ын тэргүүн
13. Д.Бараадууз Ойн хишиг ТББ-ын тэргүүн
14. Ц.Бат-Өлзий Өмнөговь аймгийн Ахмадын хороо
15. Л.Цэцэг-Өлзий Хариуцлага-Уул уурхай ТББ

### **Улаанбаатар хот дахь гишүүд**

- |                   |   |
|-------------------|---|
| 16. П. Очирбат    | Монголын Уул уурхайн үндэсний ассоциаци                     |
| 17. С.Ганбаатар   | Монголын Үйлдвэрчний эвлэлийн Ерөнхийлөгч                   |
| 18. Д. Сүхбаатар  | ТХХУУС* ТББ-ын Удирдах Зөвлөлийн гишүүн                     |
| 19. Б.Чинзориг    | ТХХУУС ТББ-ын Удирдах Зөвлөлийн гишүүн                      |
| 20. Б. Баярмаа    | “Монгол нутаг мину” эвсэл                                   |
| 21. Л. Долгормаа  | Дэлхийн байгаль хамгаалах сан (ТББ)                         |
| 22. Г. Уранцоож   | Хүний эрх, хөгжил төв (ТББ)                                 |
| 23. Ч. Дэлгэрмаа  | Хүний эрх, хөгжил төв (ТББ)                                 |
| 24. Н.Дорждарь    | Нээлттэй нийгэм форум                                       |
| 25. Б.Лхагважав   | “Соёмбо” хөдөлгөөн  |
| 26. Б.Бат         | МУИС, Эдийн засгийн сургууль                                |
| 27. С.Чулуунхуяг  | ШУТИС, Тогтвортой хөгжил экологийн төв                      |
| 28. Т. Намнан     | Технологи инновацийн залуу судлаачдын нийгэмлэг             |
| 29. Г.Цэрэндондов | Байгаль орчны яам   |
| 30. Б.Ганбат      | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам                         |
| 31. Л. Нарантуяа  | Эрүүл мэндийн яам   |
| 32. И. Болормаа   | Эрүүл мэндийн яам   |
| 33. П. Ганхуяг    | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам                  |
| 34. Ч. Нэргүй     | Монголын Худалдаа аж үйлдвэрийн танхим                      |
| 35. Х.Мөнгөнтуяа  | Зам, тээвэр, аялал жуулчлалын яам                           |
| 36. Н.Аюуш        | Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам                         |
| 37. Б.Батхуяг     | Дэлхийн байгаль хамгаалах сан, Монголын Хөтөлбөрийн менежер |
| 38. Х.Бадамсүрэн  | УИХ-ын гишүүн, Өмнөговь аймгийн нутгийн зөвлөл              |

\* Тогтвортой хөгжил, хариуцлагатай уул уурхайн санаачлага

### **Зөвлөх хорооны Ажлын алба**

- |                |            |
|----------------|------------|
| 1. Б.Арвинбаяр | ТХХУУС ТББ |
| 2. Ч.Ундрам    | ТХХУУС ТББ |

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АСЭХ	Ардчилсан Социалист Эмэгтэйчүүдийн Холбоо
АХА	“Асуулт- Хариулт-Асуулт”
АХОТ	Ажиллах хүчний оролцооны түвшин
ББН	Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл
БЗДХ	Бэлгийн замаар дамжих халдвар
БЗХӨ	Бэлгийн замын халдварт өвчин
БМААЭУ	Бэлчээрийн мал аж ахуйн Эрсдэлийн удирдлага
БНН	Бүгд найрамдах нам
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БОХА	Байгаль орчны хяналтын алба
БСГ	Боловсрол, Соёлын Газар
БСТ	Бодлого Судлалын Төв
БСШУЯ	Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам
ГТ	Газар тариалан
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДОХ	Дархлалын олдмол хомсдол
ДЦС	Дулааны цахилгаан станц
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЕХ	Европын Холбоо
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэр
ЗБН	Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ЗХЖШ	Зэвсэгт Хүчний Жанжин Штаб
ИЗН	Иргэний зориг нам
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МАА	Мал аж ахуй
МАН	Монгол ардын нам
МАСМН	Монголын ардчилсан сэргэн мандалтын нам
МАХН	Монгол ардын хувьсгалт нам
МАШН	Монголын шашинтны ардчилсан нам
МЛАН	Монголын либерал ардчилсан нам
МНН	Монголын ногооны нам
МоАН	Монголын ардчилсан нам
МСДН	Монголын социал-демократ нам
МСС	Мянганы сорилын сан
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
МТН	Малчин тариачны нам
МУ	Монгол Улс
МУАН	Монголын Үндэсний ардчилсан нам
МҮДН	Монголын Үндэсний дэвшлийн нам
МУНН	Монголын уламжлалын нэгдсэн нам
МУШЁН	Монголын уламжлал, шудрага ёсны нам

МҮЭНН	Монголын үндэсний эв нэгдлийн нам
МХГ	Мэргэжлийн Хяналтын Газар
МХТ	Мэдээлэл, харилцаа холбооны технологи
МХТУГ	МХТ-ийн удирдах газар
МШСДН	Монголын шинэ социал демократ нам
MORTPAK	НҮБ-аас гаргасан хөгжиж буй орнуудын хүн ам зүйн шинжилгээнд зориулсан багц програм
НБНБК	Насны бүлэг дэх нас баралтын коэффициент
НБТК	Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НТХ	Нэгдсэн төсвийн тухай хууль
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр
НҮЭМ	Нөхөн үржихүйн эрүүл мэнд
ОНСС	Орон нутгийн санаачлагын сан
ӨМӨЗО	Өвөр Монголын Өөртөө Засах Орон
ӨОЗАТС	Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний судалгаа
СЕХ	Сонгуулийн Ерөнхий Хороо
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕХ	Татварын ерөнхий хууль
ТНК	Төрөлтийн нийлбэр коэффициент
УДШ	Улсын дээд шүүх
УИХ	Улсын Их Хурал
ҮСГ	Үндэсний Статистикийн Газар
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
УТ	Улс төрийн
ҮЭ	Үйлдвэрчний эвлэл
ФСЭХ	Философ, Социологи, Эрхийн Хүрээлэн
ХАА	Хөдөө аж ахуй
ХААНТ	Хөдөө аж ахуйн нэвтрүүлэх төв
ХАОАТ	Хүн амын орлогын албан татвар
ХАССТ	Хүн Амын Сургалт, Судалгааны Төв
ХЗДХ	Хууль зүй дотоод хэргийн
ХЗХ	Харилцаа Холбооны Зохицуулах Хороо
ХК	Хувьцаат компани
ХХААГ	Хүнс, Хөдөө Аж Ахуйн Газар
ХХБ	Худалдаа Хөгжлийн Банк
ХХИ	Хүний хөгжлийн индекс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХЭҮК	Хүний Эрхийн Үндэсний Комисс
ШУА	Шинжлэх Ухааны Академи

## НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

1. **Ажил эрхлэлтийн түвшин:** Эдийн засгийн идэвхтэй хүн амын хэдэн хувийг ажил эрхэлж буй хүмүүс бүрдүүлж байгааг илэрхийлдэг. Ажиллагчид гэдэг нь ажиллах хүчинд хамаарагдах тухайн хугацаанд буюу сүүлийн 12 сард болон судалгаа авах үед ажил, хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүс юм.
2. **Ажилгүйдлийн түвшин:** Эдийн засгийн идэвхтэй хүн амд ажилгүйчүүдийн эзлэх хувийн жингээр тодорхойлогдоно. Ажилгүйчүүд гэдэгт ажиллах хүчинд хамаарагдах тухайн хугацаанд ажил, хөдөлмөр эрхлээгүй байгаа, тухайн судалгаа авах үед болон сүүлийн 12 сард ажил эрхлээгүй боловч ажил эрхлэхэд бэлэн байсан, ажил хөдөлмөр идэвхтэй хайсан хүнийг оруулсан.
3. **Ажиллах хүчний оролцооны түвшин:** Ажиллагчид болон ажилгүйчүүдийн нийлбэр буюу эдийн засгийн идэвхтэй хүн амын хөдөлмөрийн насны нийт хүн амд эзлэх хувийн жинг харуулна. Энэхүү судалгаанд хүн амын эдийн засгийн идэвхийг 15 ба түүнээс дээш насаар тооцсон бөгөөд эдийн засгийн идэвхтэй хүн ам гэдэгт НҮБ-ын үндэсний тооцооны системийн хүрээнд, тодорхой цаг хугацаанд тодорхойлогдсон бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэхэд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагчид, нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүйчүүдийг оруулдаг.
4. **Албан боловсрол:** Боловсролын албан ёсны байгууллагаар дамжуулж, суралцагчийн ерөнхий болон мэргэжлийн зохих түвшний боловсрол эзэмших хэрэгцээг хангадаг боловсролын зохион байгуулагдсан үйл ажиллагаа
5. **Албан бус боловсрол:** Албан бус боловсрол нь албан ёсны боловсролыг дэмжиж нөхөх чиглэл бүхий албан ёсны бус сургалт болон амьдрал орчноос олох боловсролыг хоёуланг багтаадаг
6. **Ачаа эргэлт:** Нийт тээвэрлэсэн ачааны хэмжээг тээвэрлэсэн зайгаар үржүүлж ачаа эргэлтийн хэмжээг тооцно.
7. **Бага боловсрол:** 1-5-р ангийн боловсрол
8. **Багш сурагчдын харьцаа:** Нэг багшид ногдох сурагчдын тоо
9. **Байгалийн нөөц газар:** Байгалийн нөөц баялгийг хамгаалах, нөхөн сэргээх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг
10. **Байгалийн цогцолборт газар:** Байгалийн унаган төрхөө харьцангуй хадгалсан шинжлэх ухааны болон танин мэдэхүйн ач холбогдол бүхий улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг
11. **Бичиг үсэг тайлагдалтын түвшин:** Кирилл үсгээр наад захын материалыг уншиж, ойлгож, бичиж чаддаг хүн амын нийт хүн амд эзлэх хувийн жин
12. **Бүлэг дүүргэлт/анги дүүргэлт:** Нэг бүлэгт ногдох хүүхдийн дундаж тоо
13. **Бүрэн бус ажил эрхлэлт:** Тухайн хүний ажлын туршлага, мэргэжлийн чадварт дүйцэхүйц бус ажил хөдөлмөр эрхэлж байгаа тохиолдолд бүрэн бум ажил эрхлэлт байдаг. Бүрэн бус ажил эрхэлж байгаа хүн нь цалин хөлстэй болон хувиараа эрхэлж байгаа тухайн үйл ажиллагаанд тогтоогдсон цагаас бага цагаар ажиллаж буй тухайн хугацаанд нэмэлт ажил хайж байгаа болон нэмэлт ажил эрхлэхэд бэлэн байгаа хүн юм.
14. **Бүрэн дунд боловсрол:** 10-11-р ангийн боловсрол
15. **Бэлчээрийн багтаамж:** 100 га бэлчээрт ногдох малын тоо, хонин толгойгоор
16. **Бэлчээрийн даац:** Тухайн бэлчээрт багтах малын тоо, хонин толгойгоор

17. **Гадаад шилжих хөдөлгөөн:** Аливаа улсын хилийг давж шилжиж буй шилжилт хөдөлгөөн. Тухайн улсад ирж буй шилжигчдийг шилжин ирэгчид, явж буй шилжигчдийг шилжин явагч гэнэ.
18. **Гадаргын ус:** газрын гадарга дээрх урсгал болон тогтмол усыг
19. **Газрын доорхи ус:** газрын гадаргуугийн гүн дор чулуулгийн ан цав, нүх сүвүүдэд орших усыг
20. **Голч нас:** Хүн амыг насны бүтцийнх нь хувьд яг таллан хувааж байгаа насыг голч нас гэнэ. Өөрөөр хэлбэл, тухайн хүн амын тал хувь нь голч наснаас дээгүүр настай, тал хувь нь голч наснаас доогуур настай байна гэсэн үг.
21. **Давхар ажил эрхлэлт:** Тухайн хугацаанд (сүүлийн 12 сард) нэгээс олон ажил цалинтай болон хувиараа эрхэлж байгаа бол нийгмийн болон хууль зүйн тал, цалин хөлсний хэмжээ, ажиллаж байгаа цагаас нь хамааруулан үндсэн ажлаас бусад ажлыг давхар ажил гэж тодорхойлно. Хэрвээ тухайн хүн зөвхөн нэг л ажил эрхэлдэг бол түүнийг үндсэн ажилд тооцно.
22. **Дархан цаазат газар:** Байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг
23. **Дотоод шилжих хөдөлгөөн:** Аливаа улсын хилийн доторх шилжилт хөдөлгөөн.
24. **Дотоодын нийт бүтээгдэхүүн:** (ДНБ) тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд нэг жилийн хугацаанд дотоод, гадаадын эдийн засгийн харъяатуудад (аж ахуйн нэгж, байгууллага, иргэд) шинээр бий болсон нийт нэмэгдэл өртгийг хэлнэ.
25. **Жини коэффициент:** Нэг хүнд ногдох хэрэглээнд (үнийн зохицуулалт хийсэн) тулгуурлан тооцсон хэрэглээний ялгааг харуулдаг индекс юм. Жини коэффициент ихэнх улс оронд 0.2-0.5-ын хооронд байдаг. Энэ коэффициент нь 0 гэсэн утга авбал тэнд тэгш бус байдал байхгүйг, харин 1 гэсэн утга авбал бүх орлого, нөөцийг 1 хүний хараанд байна гэсэн ойлголт юм.
26. **Зорчигч эргэлт:** Нийт зорчигчдын тоог тээвэрлэсэн зайгаар үржүүлж, зорчигч эргэлтийн хэмжээг тооцно.
27. **Малтай өрх:** Малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрхийг хэлнэ.
28. **Малчин өрх:** Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа өрхийг хэлнэ.
29. **Насжилтын хүснэгт:** Дундаж наслалтыг хүн ам зүйн шинжлэх ухаанд статистикийн нэгэн онцгой загвараар буюу насжилтын хүснэгтийг боловсруулж тооцдог. Насжилтын хүснэгтийг насны бүлэг тус бүрээр тооцсон нас баралтын коэффициентүүдийн үндсэн дээр дараагийн насанд (насны бүлэгт) шилжин амьдрагсдын тоо, дундаж наслалтыг тодорхойлох замаар боловсруулдаг. Насжилтын хүснэгт нь хүн амын нас баралтын талаар эмх цэгцтэй мэдээлэл өгдөг.
30. **Овог** - Нэг ураг төрлийнхөн буюу ясныхан нь ураг төрлийн салаануудад хуваагдах ба үүнийг овог гэдэг.
31. **Стандарт хангалт:** Сурагчдын авсан нийт дүнд “F”-ээс бусад дүнгийн эзлэх хувь
32. **Сургууль завсардалтын хувь:** ЕБС-ийн нийт суралцагчдад ЕБС-д сураагүй байгаа 7-15 насны хүүхдүүдийн эзлэх хувийн жин
33. **Сурагчдын чанар:** Сурагчдын авсан нийт дүнд “А” ба ”В”-ийн эзлэх хувь
34. **Суурь боловсрол:** 6-9-р ангийн боловсрол



35. **Тейлийн индекс:** Тейлийн тэгш бус байдлын индексийг өргөн хэрэглэдэг. Янз бүрийн бүлгээр болон бүс нутгаархи ялгааг харуулна.
36. **Төрөл бүрийн малын тооны харьцаа:** Нэг төрлийн малын тоог нөгөөд нь шууд юм уу бод, хонин толгойд шилжүүлж харьцуулсан үзүүлэлт. Энэхүү харьцааг тооцоолох замаар тухайн төрлийн малын тоо толгойн өсөлтийн хурдац, сүрэгт эзэлж буй хувийн жингийн талаар ойлголт авахад чухал
37. **Төрөлтийн нийлбэр коэффициент (ТНК):** Төрөлтийн нийлбэр коэффициент (ТНК) нь тухайн онд нэг эмэгтэй нөхөн үржихүйн амьдралын хугацаагаа дуустал нас барахгүй гэж үзвэл нөхөн үржихүйн амьдралынхаа сүүл үе гэхэд төрүүлсэн байх нийт хүүхдийн тоо юм. ТНК нь бүх эмэгтэйчүүдийн тухайн цаг үе дэх төрөлтийн тоог нэгтгэн, нэг эмэгтэйд ногдох байдлаар тооцдог. Энэ санааг тусган, ТНК-ийг тодорхойлбол, хэрэв тухайн цаг үеийн төрөлтийн түвшин эмэгтэйн нөхөн үржихүйн амьдралын бүхий л хугацаанд хадгалагдана гэж үзвэл нэг эмэгтэйн төрүүлэх нийт хүүхдийн тоо юм.
38. **Төрөлтөөс тооцсон дундаж наслалт:** Дундаж наслалт нь насны бүлэг дэх нас баралтын коэффициентийг үндэслэн тооцсон тухайн хүний цаашид амьдрах дундаж хугацаагаар тодорхойлогддог. Төрөлтөөс (0 насны хүн амын хувьд) тооцсон дундаж наслалт нь насжилтын хүснэгтээр тооцогдсон 0 насны бүлгийн хүн амын цаашид амьдрах хүн жил болно.
39. **Тэжээлийн нэгж:** Сайн чанарын 1 кг арвайн тэжээллэг чанарыг нэг нэгжээр авч бусад төрлийн тэжээлийг жишиж гаргасан үзүүлэлт: 1 кг өвсний тэжээллэг чанар – 0.3-0.45, хүчит тэжээл – 0.8-1.0, гар тэжээл – 0.8-1.0, дарш – 0.2 гэх мэт
40. **Угсаатны бүлэг:** Гарал үүсэл, хэл, соёл, зан заншил, газар нутаг, түүхэн туршлага нэгтэй хэсэг бүлэг хүмүүс.
41. **Үндэсний орлого:** Тухайн улсын эдийн засгийн харьяатуудад шинээр бий болсон нийт нэмэгдэл өртгийг хэлнэ. Үндэсний нийт орлогын хэмжээг ДНБ-ээс гадаад орны эдийн засгийн харьяатуудад бий болсон нэмэгдэл өртгийг хасч, гадаадад суугаа өөрийн орны эдийн засгийн харьяатуудад бий болсон нэмэгдэл өртгийг нэмж тодорхойлно.
42. **Усны нөөц:** Одоо ашиглаж байгаа, цаашид ашиглаж болох гадаргын болон газрын доорхи усыг
43. **Хамран сургалтын хувь/бохир жингээр/:** Боловсролын тухайн шатанд суралцвал зохих насны 100 хүүхэд тутамд ногдох тухайн шатанд суралцаж байгаа нийт суралцагчдын тоо
44. **Хамран сургалтын хувь/цэвэр жингээр/:** Боловсролын тухайн шатанд суралцвал зохих насны 100 хүүхэд тутамд ногдох тухайн шатанд суралцвал зохих насны суралцагчдын тоо
45. **Химийн хорт бодис:** Хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд хортой нөлөө үзүүлэх, улмаар үхэл, мөхөлд хүргэх үйлчилгээтэй химийн бодис, тэдгээрийн нэгдлийг
46. **Хонин толгой:** Бэлчээрээс идэх өвсний хэмжээнд үндэслэсэн тусгай илтгэлцүүрээр малын тоог хоньтой жишсэн нэгжид шилжүүлсэн илэрхийлэл: 1 тэмээ – 5, адуу – 7, үхэр – 6, хонь - 1, ямаа - 0.9 хоньтой тэнцэнэ.
47. **Хотжилт:** Хотод амьдарч буй хүн амын хувийн жингийн өсөлтийг хотжилт гэнэ.
48. **Хөдөлмөр эрхлэлтийн мэдрэмжийн түвшин:** Ажил эрхлэлтийн түвшний өөрчлөлт, ДНБ-ний өсөлтийн өөрчлөлтийн харьцаагаар тодорхойлогдох үзүүлэлт.
49. **Хөрөнгө оруулалт:** Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хуримтлалыг шинээр буй болгох, түүний техникийн зэвсэглэмжийг дээшлүүлэн өргөтгөх, сайжруулахад зориулж, тайлант жилд зарцуулсан хөрөнгө, хайгуулын ажлын зардлыг хэлнэ.

50. **Хүйсийн харьцаа:** Эрэгтэй хүн амын тоог эмэгтэй хүн амын тоонд харьцуулсан харьцааг хүйсийн харьцаа гэнэ. Энэ нь ихэвчлэн 100 эмэгтэйд ногдох эрэгтэйн тоогоор илэрхийлэгддэг.
51. **Хүн ам зүйн ачаалал:** Эдийн засгийн хувьд хараат буюу “тэжээлгэгч” (0-14 насны хүүхдүүд болон 65+ насныхан) хүн ам болон хөдөлмөрийн насны (15-64 насны) хүн амын харьцаагаар илэрхийлэгдэнэ. Өөрөөр хэлбэл 15-64 насны 100 хүн тутамд ногдох 0-14 ба 65+ насны хүн амын тоо юм. Энэ үзүүлэлтийг хүүхдүүд болон өндөр настнуудын хувьд тус тусад нь тооцож болдог.
52. **Хүн амыг хэрэглээний түвшингээр нь тэнцүү 5 бүлэгт хуваах арга:** Хүн амыг хэрэглээний түвшингээр нь тэнцүү 5 бүлэгт хуваах (нэг хүнд ногдох хэрэглээний хэмжээгээр нь хүн амын ядуугаас нь баян руу нь эрэмблэн, улмаар 20, 20 хувиар буюу тэнцүү 5 бүлэгт хуваана) арга юм.
53. **Хүн амын насжилт:** Төрөлт нас баралтын бууралтын нөлөөгөөр насанд хүрэгсэд болон өндөр настай хүн амын нийт хүн амд эзлэх хувийн жин нэмэгддэг. Хүн амын насжилт нь хүн амын нас баралт буурч, дундаж наслалт уртсаж байгаагийн эерэг үр нөлөө боловч нөгөөтэйгүүр төрөлтийн бууралтын үр нөлөөгөөр залуу насны хүн ам буурч байгаагаас шалтгаалж байгаа юм. Хэрэв хөгшин настай хүн амын тоо өсөхгүй байгаа тохиолдолд хүн амын насжилт нь хүн ам зүйн шилжилтийн үр нөлөө байх болно.
54. **Цалин хөлстэй ажил эрхлэлт:** Цалин хөлс, ашиг орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож мөнгөн болон биет хэлбэрээр ажил олгогчоос цалин хөлс, урамшуулал, гарын мөнгө, ашиг орлогын хувь, илүү цаг ажилласны мөнгө авдаг ажиллагчдыг хамааруулна.
55. **Цэвэр шилжилт:** Тухайн тооцоолж буй хугацаанд аливаа нутаг дэвсгэрт нэвтрэн орж буй болон тухайн нутаг дэвсгэрийг орхин гарч буй хүн амын тооны зөрүүг цэвэр шилжилт гэнэ.
56. **Шилжих хөдөлгөөн:** Төрсөн газар эсвэл оршин сууж буй газраа өөрчилж буй хувь хүний шилжилтийг шилжих хөдөлгөөн гэнэ.
57. **Эдийн засгийн үйл ажиллагаан дах хөлсгүй ажил эрхлэлт:** Мал маллах, хариулах, өсгөх, мал аж ахуйн бүтээгдэхүүн бэлтгэх, боловсруулах гэх мэт мал аж ахуйн холбогдолтой ажлууд, өрхийн аж ахуйн хэрэглээндээ зориулан цалин хөлс авахгүйгээр хүнсний ногоо, үр тариа, тэжээл ургуулах, арчлах, бүтээгдэхүүн, үйлчилгээ эрхлэх зэрэг орно. Өрхийн үндсэн хөрөнгө үйлдвэрлэх, тухайлбал барилга, байшин барих мөн хамаарна.
58. **Элсэлтийн хувь:** Элсвэл зохих насны 100 хүүхэд тутамд ногдох сургуульд шинээр элссэн хүүхдийн тоо
59. **Ядуурлын гүнзгийрэлтийн индекс:** Ядуурлын шугамаас ядуучуудын хэрэглээ хэр зэрэг доогуур байгааг илэрхийлдэг. Хэрэглээний дутагдал их байх тутам гүнзгийрэл өндөр байх бөгөөд ядуурлын хамрагдалтын хүрээний индексийн дутагдалтай талыг засдаг.
60. **Ядуурлын мэдрэмжийн индекс:** Ядуучуудын дундах хэрэглээний тархалтын мэдрэмж бөгөөд ядуучуудын бүлэг хооронд хийсэн шилжүүлэг нь ядуурлын хамрагдалт, ядуурлын гүнзгийрлийг өөрчлөхгүй, харин мэдрэмжийг өөрчилнө. Ядуурлын гүнзгийрэл их байх тутам ихээр жигнэнэ гэсэн үг юм.

61. **Ядуурлын хамралтын индекс:** Нийт хүн амд ядуу хүн амын эзлэх хувийн жингээр тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл, ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй хүн амын нийт хүн амд эзлэх хувийн жин юм.